



VIII/2021


Тархаасан: 9 дүгээр сарын 10



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.4 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.9 хувь, өмнөх оны эцсээс 8.9 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.7 хувь (мах, махан бүтээгдэхүүн 16.8 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 8.6 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 7.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 8.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 16.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 15.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар буурсан хэдий ч (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6.1 хувиар буурсан), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2021 оны 8 дугаар сард

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | <u>2021 VIII</u> 2020 VIII | <u>2021 VIII</u> 2020 XII | <u>2021 VIII</u> 2021 VII |
|---|--------------|-------------------------------|------------------------------|------------------------------|
| Ерөнхий индекс | 100.0 | 108.9 | 108.9 | 100.4 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 26.1 | 113.7 | 113.3 | 97.8 |
| Согтууруулах ундаа, тамхи | 4.4 | 103.8 | 103.3 | 100.5 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.6 | 104.0 | 101.8 | 100.6 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 9.3 | 107.0 | 116.5 | 102.1 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.9 | 106.8 | 105.4 | 100.9 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 106.4 | 104.7 | 100.9 |
| Тээвэр | 14.4 | 116.3 | 115.3 | 102.7 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 100.4 | 100.3 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 3.1 | 102.9 | 102.4 | 100.8 |
| Боловсролын үйлчилгээ | 4.8 | 103.2 | 103.2 | 102.8 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 3.0 | 113.4 | 112.2 | 101.2 |
| Бусад бараа, үйлчилгээ | 5.4 | 106.0 | 104.5 | 101.5 |

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 8 дугаар сард 6.0 хувь, 2019 оны 8 дугаар сард 8.9 хувь, 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь гарч байсан бол 2021 оны 8 дугаар сард 8.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 6.8 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 8 дугаар сард

| Бараа, үйлчилгээний бүлэг | 2018 VIII | 2019 VIII | 2020 VIII | 2021 VIII |
|---|------------|------------|------------|------------|
| Ерөнхий индекс | 6.0 | 8.9 | 2.1 | 8.9 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 1.4 | 3.4 | 1.2 | 3.7 |
| Согтууруулах ундаа, тамхи | 0.3 | 0.2 | 0.2 | 0.2 |
| Хувцас, бөс бараа, гутал | 0.6 | 1.5 | 0.7 | 0.7 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 1.0 | 1.2 | 0.2 | 0.7 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 0.3 | 0.2 | 0.2 | 0.3 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 0.5 | 0.3 | 0.1 | 0.2 |
| Тээвэр | 0.8 | 0.5 | -0.8 | 2.1 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 0.3 | 0.4 | 0.0 | 0.1 |
| Боловсролын үйлчилгээ | 0.3 | 0.5 | 0.0 | 0.2 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.2 | 0.3 | 0.1 | 0.4 |
| Бусад бараа, үйлчилгээ | 0.3 | 0.3 | 0.3 | 0.3 |

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.9 хувь гарсны 3.7 нэгж хувь буюу 41.6 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгж хувиар, жил бүрийн 8 дугаар сард

| Үзүүлэлт | 2019 VIII | | 2020 VIII | | 2021 VIII | |
|------------------------|------------|--------------|------------|--------------|------------|--------------|
| | Нэгж хувь | Хувь | Нэгж хувь | Хувь | Нэгж хувь | Хувь |
| Ерөнхий индекс | 8.9 | 100.0 | 2.1 | 100.0 | 8.9 | 100.0 |
| Импортын барааны нөлөө | 2.9 | 32.6 | 0.5 | 23.8 | 4.4 | 49.4 |

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.

Инфляц 2021 оны 8 дугаар сард 8.9 хувь гарсны 49.4 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 25.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 8 дугаар сард 4.5 хувиар, 2021 оны 8 дугаар сард 12.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 7.9 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 8 дугаар сард 0.9 хувиар, 2021 оны 8 дугаар сард 7.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 6.4 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 8 дугаар сард

| Огноо | Хүнс, хүнсний бус | Улс | Улаанбаатар | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс |
|-----------|-----------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| | Ерөнхий индекс | 102.1 | 101.7 | 102.4 | 102.1 | 102.8 | 104.0 |
| 2020 VIII | Хүнс | 104.5 | 103.5 | 106.5 | 104.7 | 106.2 | 107.0 |
| | Хүнсний бус | 100.9 | 100.6 | 101.0 | 101.1 | 101.3 | 102.7 |
| | Ерөнхий индекс | 108.9 | 109.1 | 109.0 | 108.2 | 109.1 | 107.9 |
| 2021 VIII | Хүнс | 112.4 | 111.4 | 114.5 | 114.7 | 112.6 | 113.7 |
| | Хүнсний бус | 107.3 | 108.0 | 107.0 | 105.7 | 107.6 | 105.4 |

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индексийг хүнс, хүнсний бус бүлгээр авч үзэхэд 2021 оны 8 дугаар сард Хангайн бүсэд хүнсний бүлгийн үнэ 14.7 хувиар, Улаанбаатар хотод хүнсний бус бүлгийн үнэ 8.0 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Барааны бүлгийн үнэ 2020 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, 2021 оны 8 дугаар сард 10.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 8.0 нэгж хувиар нэмэгдэж, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 8 дугаар сард 1.1 хувиар, 2021 оны 8 дугаар сард 4.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.2 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 8 дугаар сард

| Огноо | Бараа, үйлчилгээ | Улс | Улаанбаатар | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс |
|-----------|-----------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| | Ерөнхий индекс | 102.1 | 101.7 | 102.4 | 102.1 | 102.8 | 104.0 |
| 2020 VIII | Бараа | 102.4 | 101.8 | 103.0 | 102.5 | 103.2 | 104.4 |
| | Үйлчилгээ | 101.1 | 101.3 | 100.3 | 100.4 | 101.1 | 102.3 |
| | Ерөнхий индекс | 108.9 | 109.1 | 109.0 | 108.2 | 109.1 | 107.9 |
| 2021 VIII | Бараа | 110.4 | 110.9 | 110.6 | 109.3 | 110.5 | 109.0 |
| | Үйлчилгээ | 104.3 | 104.7 | 103.7 | 103.9 | 103.3 | 103.4 |

Энэ оны 8 дугаар сард Улаанбаатар хотод барааны бүлгийн үнэ 10.9 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 4.7 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 26.8 хувиар өсөж, өмнөх сараас 6.1 хувиар буурлаа. Өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 17.5 хувь, хонины ястай махны үнэ 17.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны эцсээс 10.0 хувь, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 12.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 8.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 15.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 18.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 10.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 13.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 25.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 15.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувиар буурсан хэдий ч, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2021 оны 8 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 27.0 хувь буюу 93 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 11.3 хувь буюу 39 бараа, үйлчилгээний үнэ буурч, 61.6 хувь буюу 212 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 37 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 8 дугаар сард 15419 төгрөг болж, 2018 оны 8 дугаар сараас 54.5 хувь, 2019 оны 8 дугаар сараас 11.1 хувь, 2020 оны 8 дугаар сараас 12.8 хувиар, өмнөх оны эцсээс 22.9 хувь буюу 2868 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 6.8 хувь буюу 1125 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 8 дугаар сард 13700 төгрөг болж, 2018 оны 8 дугаар сараас 66.7 хувь, 2019 оны 8 дугаар сараас 18.7 хувь, 2020 оны 8 дугаар сараас 16.6 хувиар өсөж, өмнөх оны эцсээс 22.2 хувь буюу 2492 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 7.4 хувь буюу 1093 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай махны 1 кг дундаж үнэ 2021 оны 8 дугаар сард 11380 төгрөг болж, 2018 оны 8 дугаар сараас 63.1 хувь, 2019 оны 8 дугаар сараас 17.3 хувь, 2020 оны 8 дугаар сараас 15.4 хувь, өмнөх оны эцсээс 32.6 хувь буюу 2801 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 8.5 хувь буюу 1060 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 8 дугаар сард 2047 төгрөг болж, 2018 оны 8 дугаар сараас 12.5 хувь, 2019 оны 8 дугаар сараас 11.7 хувь, 2020 оны 8 дугаар сараас 45.8 хувь, өмнөх оны эцсээс 42.9 хувь буюу 615 төгрөг, өмнөх сараас 0.1 хувь буюу 3 төгрөгөөр тус тус өссөн байна.


Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 5.5-12.9 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 8 дугаар сард Хөвсгөл аймагт 5.5 хувиар өссөн нь хамгийн бага, Баянхонгор аймагт 12.9 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 8 дугаар сард (өмнөх оны мөн үеэс)



ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 дугаар сард, төгрөгөөр



Аймгуудад 2021 оны 8 дугаар сард худалдаалагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 10179 төгрөг болж, 2020 оны 8 дугаар сараас дунджаар 1760 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 2653 төгрөгөөр их байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 8 дугаар сард Говьсүмбэр аймагт 8500 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 12000 төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_t^i - *i* барааны тайлант үеийн үнэ

P_o^i – *i* барааны суурь үеийн үнэ

Q_o^i - *i* барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.

Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



Эх үүсвэр: ҮСХ,Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код: ХЗХБҮА

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Батсүх, Т.Жигжидсүрэн
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212